



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Оноосон нэр өөрчилснийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даатгалын зуучлагч “Соёмбо брокер” ХХК-ийн оноосон нэрийг “Паблик паст брокер” ХХК болгон өөрчилснийг бүртгэсүгэй.

2. Оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгүүдийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Соёмбо брокер” ХХК /С.Амингавъяат/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН